

1.8	Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй	
1.9	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх	
1.10	Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглох	
1.11	Цохилтод өрмөөр өрөмдсөн тохиолдолд цооногийн нийт гүнд хамгаалалтын хуванцар хоолой хийнэ.	
2	Худгийн барилга, усан сан, мал услах онгоц, талбай барих	
2.1	Худгийн барилга <ul style="list-style-type: none"> • Хэмжээ /дотор талдаа/: 3м х 3м, ханын өндөр шалнаас дээш 2 м • Материал: тоосго, блок, модон • Ханын зузаан: Тоосго ханын зузаан 38 см-аас багагүй • Ханыг гадна, дотор талаас нь шавардаж, цагаан өнгөөр будна. • Хаалга нь 3 мм зузаантай листэн төмөр хаалга байна. • Худгийн барилгын суурийн гүн 0.5 метрээс багагүй байна. • Худгийн дээр 30см х30см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ. Нээлхий нь цооногт засвар, үйлчилгээ хийхэд зориулагдана. • Худгийн цонх нь 40см х 50 см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /Цонхны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана/ 	
2.2	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 50мм диаметртэй, гаднах ханаас 2м урттай, худгийн шалнаас 60 см-ийн өндөрт гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргана.	
2.3	Ундны ус авах хоолой нь: 50 мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргасан /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/ байна.	
2.4	40 мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.	
2.5	Усан сан нь босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1.5м ³ -ээс багагүй багтаамжтай, ган усан сан байна. Усан сан нь дээгүүрээ модон тагтай, нөөцийн сангийн доод хэсэг нь шалнаас 20 см өндөртэй /	
2.6	Мал услах онгоцны: <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: 9м-ээс багагүй урттай байна. • Материал 400 мм-ийн голчтой, 1.5 мм-ийн зузаантай төмрөөр хагас цилиндр хэлбэртэй эсвэл цутгамал төмөр бетон /онгоцны дээд ирмэг газраас 50 см өндөр байна/ • Мал услах онгоцны доод хэсэг газраас 20 см байна • Онгоцыг худгийн барилгаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна. • Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эргэдэж хаадаг байхаар хийнэ. • Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулан гагнана. • Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна. 	
2.7	Мал услах талбай: <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: Нийт уртын дагуу 2 талдаа 2 м-ийн өргөнтэй, зузаан нь 15 см-аас доошгүй. • Материал: 150 маркаас доошгүй чанартай цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэсэн байна. • Мал услах талбай нь худгийн барилга болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэх зориулалттай байна. 	
3	Худгийн ус шахуурга, ус өргөх хоолой, шүүр яндан, цахилгаан үүсгүүр	